

**МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ
САЙДЫН ТУШААЛ**

2025 оны ... сарын ... өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт,
төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага
стандарт, батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9, 22.11 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Аж ахуйн нэгжийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлсэн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (П.Алтан-Од)-д даалгасугай.

3.Тушаалын хавсралтаар баталсан албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага, стандартыг аж ахуйн нэгж, иргэдэд сурталчлан таниулж ажиллахыг Харилцаа холбооны бодлого зохицуулалтын газар (Д.Баясгалан), Инновацийн бодлого зохицуулалтын газар (П.Мөнхбат)-т тус тус үүрэг болгосугай.

4.Албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан аж ахуйн нэгж нь шаардлага, стандартыг хангаагүй нь тогтоогдсон тохиолдолд энэ талаар тухай бүр татварын албанд мэдэгдэж ажиллахыг Салбарын хяналтын газар (С.Цагаанхүү)-т даалгасугай.

5.Татварын албатай тухай бүр мэдээлэл солилцож, албан татварын хөнгөлөлтөд хамрагдсан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагааны статистик мэдээллийг нэгтгэн хагас жил тутам тайлагнаж ажиллахыг Стратеги, бодлого, төлөвлөлтийн газар (Ш.Батзаяат)-т үүрэг болгосугай.

6.Энэ тушаалыг 2035 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл дагаж мөрдсүгэй.

Ц.БААТАРХҮҮ

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
сайдын 2025 оны дугаар сарын -ны
өдрийн дугаар тушаалын дүгээр хавсралт

**ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН САЛБАРТ
АЖ АХУЙН НЭГЖИЙН ОРЛОГЫН АЛБАН ТАТВАРЫН ХӨНГӨЛӨЛТ ЭДЛЭХ
БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ТӨСӨЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ
ШААРДЛАГА**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Аж ахуйн нэгжийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт хэрэгжүүлсэн аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлтөд хамрагдах бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тодорхойлох, түүнд хяналт тавихад энэхүү шаардлагыг баримтална.

1.2.Монгол Улсын нутаг дэвсгэрт албан татвар төлөгчийн орлого олох үйл ажиллагаатай хамааралгүй, нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн энэ шаардлагын 2.1-т заасан бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив олгосон татвар төлөгч аж ахуйн нэгж байгууллагад энэхүү шаардлага хамаарна.

**Хоёр.Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт,
төсөл, үйл ажиллагаа**

2.1.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.2-т заасан хөнгөлөлтөд дараах үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээнд оруулсан хөрөнгө оруулалтыг хамруулна:

2.1.1.телевизийн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй, хадмал тайлбартай нэвтрүүлэх;

2.1.2.цахим хуудсыг Веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (WCAG- Web Content Accessibility Guidelines)-д нийцүүлэн хөгжүүлэх;

2.1.3.цахим ур чадварыг дээшлүүлэх, цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр мэдлэг олгох сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;

2.1.4.цахим ур чадварыг дээшлүүлэх, цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр хэвлэмэл болон цахим гарын авлага боловсруулах, контент бүтээх, олон нийтэд түгээх;

2.1.5.мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;

2.1.6.хүүхдийн цахим аюулгүй байдлыг хангахад чиглэсэн программ хангамж, платформ бүтээх, хөгжүүлэх.

2.2.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.10-т заасан хөнгөлөлтөд дараах үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээг хамруулна:

2.2.1.Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санд өгсөн хандив;

2.2.2.Өргөн нэвтрүүлгийг хөгжүүлэх санд өгсөн хандив.

2.3.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.9.11-т заасан хөнгөлөлтөд дараах төсөл, арга хэмжээг хамруулна:

2.3.1.мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих Виртуал бүсэд бүртгэгдсэн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт, хуулийн этгээдэд өгсөн санхүүгийн дэмжлэг, хандив.

Гурав.Татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах нийтлэг шаардлага

3.1.Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд оруулсан хөрөнгө оруулалт нь дараах шаардлагыг хангасан байна:

3.1.1.татвар төлөгчийн нийгмийн хариуцлагын хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэрт өөрийн, эсхүл өөр хуулийн этгээдийн элэгдэл тооцох үндсэн хөрөнгөд оруулсан бодитой хөрөнгө оруулалт байх;

3.1.2.татвар төлөгчийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8.1, 8.5-д заасан үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй байх;

3.1.3.татвар төлөгчийн өөрийн хэрэгжүүлэх бүтээн байгуулалт, төслийн хувьд тухайн татвар төлөгчийн удирдах дээд байгууллагын баталсан бизнесийн төлөвлөгөөнд туссан, санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх;

3.1.4.татвар төлөгч бусад этгээдэд хөрөнгө оруулалт хийх тохиолдолд тухайн этгээдтэй төсөл, үйл ажиллагаанд нь хөрөнгө оруулалт хийх гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлж, хөрөнгө оруулалт авч буй талын санхүүгийн тайланд элэгдэл тооцох үндсэн хөрөнгөөр бүртгэгдсэн байх.

3.2.Хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд үзүүлсэн санхүүгийн дэмжлэг, хандив нь дараах шаардлагыг хангасан байна:

3.2.1.хариу төлбөргүй шилжүүлсэн мөнгөн болон биет бус хөрөнгө байх;

3.2.2.санхүүгийн дэмжлэг, хандив хүлээн авч буй этгээд нь санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хандив олгох татвар төлөгчтэй Татварын ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан харилцан хамааралтай этгээд биш байх;

3.2.3.санхүүгийн дэмжлэг, хандив олгосон болон хүлээн авсан этгээд нь тухайн санхүүгийн дэмжлэг, хандивыг энэ шаардлага, стандартад заасан гэрээнд тусгасан зориулалтын дагуу тухайн тайлант хугацаанд зарцуулсныг

хүлээн зөвшөөрч, гэрээг цуцлах, татгалзах нөхцөл үүсээгүй талаар акт үйлдэж, нотариатаар гэрчлүүлсэн байх;

3.2.4.Иргэний хуульд заасныг баримтлан санхүүгийн дэмжлэг, хандивын тусгай зориулалтыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 22.9-д нийцүүлэн тусгасан гэрээ байгуулж, гэрээг нотариатаар гэрчлүүлсэн байх;

3.2.5.санхүүгийн дэмжлэг, хандивын зардал нь Татварын ерөнхий хуулийн 28.5-д заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар баталгаажсан байх;

3.2.6.хандив тусламжаар нийлүүлж буй тохижилт, тоног төхөөрөмж нь стандартад нийцсэн, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, орчин үеийн дэвшилтэт техник, технологи байх.

3.3.Энэ шаардлага, стандартын 2.1, 2.2-т заасан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.1, 13.1.3, 13.1.4, 13.1.5-д заасан хасагдах зардлын шаардлагыг хангасан байна.

3.4.Энэ шаардлагын 2-т заасан бүтээн байгуулалт, төсөл, арга хэмжээнд хөрөнгө оруулсан, санхүүгийн дэмжлэг, хандив үзүүлсэн албан татвар төлөгч хуулийн этгээд нь хавсралтад заасан стандартыг хангасан байна.

3.5.Албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд хүснэгт 1-д заасан бусад шаардлага, стандартыг хангасан байна.

Дөрөв.Хяналт, баталгаажуулалт

4.1.Энэ журмын 2-т заасан хөнгөлөлт эдлэх үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангасан эсэхэд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хяналт тавина.

4.2.Татварын байгууллага албан татварын хөнгөлөлтөд хамрагдахаар ирүүлсэн татвар төлөгчийн тайлант үеийн татварын хөнгөлөлтийн мэдээллийг жил бүрийн 3 дугаар сарын 01-ний өдрийн дотор цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

4.3.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага ирүүлсэн мэдээллийг энэ шаардлагын хавсралтад заасан тавигдах стандартыг хангасан эсэхийг 30 хоногийн дотор хянаж, баталгаажуулан татварын байгууллагад хүргүүлнэ.

4.4.Хөнгөлөлт эдлэх татвар төлөгч нь хөрөнгө оруулах төсөл, арга хэмжээний гэрээний нотариатаар баталгаажуулсан хуулбарыг тайлант онд багтаан цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж, бүртгүүлнэ.

Тав.Бусад

5.1.Татвар төлөгч нь энэ шаардлагын 2-т заасныг татвараас зайлсхийх үндсэн зорилгоор ашигласан тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

5.2.Аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив нь нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулагдаагүй, гэрээний хэрэгжилт хангагдаагүй нь тогтоогдсон тохиолдолд татварын холбогдох хуульд заасны дагуу хөнгөлөлт эдлүүлэх үндэслэл болохгүй.

--- о0о ---

Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны
сайдын 2025 оны дугаар сарын-ны өдрийн
.... дугаар тушаалын хавсралтаар баталсан
шаардлагын хавсралт

**ШААРДЛАГАД ДУРДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ
ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ДАГАЖ МӨРДӨХ СТАНДАРТ**

№	Хуулийн заалт, чиглэл, зориулалт	Зорилго, үндэслэл	Холбогдох стандарт, журам	Тавигдах доод шаардлага	Тусгай шаардлага
Нэг. Харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг хүргэхэд чиглэсэн аж ахуйн нэгжийн оруулсан хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг, хандив, тусламж					
1	Харилцаа холбооны тухай хуулийн 6.1.6, 9.1.7, 11.2; Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.2, 9.3;	төрийн бодлогын хүрээнд харилцаа холбооны зайлшгүй шаардлагатай үйлчилгээг алслагдсан орон нутагт болон үйлчилгээ хүрээгүй хүн амд бодит үнээр хүргэх, шинээр сүлжээ байгуулах, харилцаа холбооны орчин үеийн дэвшилтэт технологийг	Засгийн газрын 2023 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам”	Харилцаа холбооны үйлчилгээг хүргэх талаарх төрийн болон салбарын бодлогод нийцсэн байх; Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх	амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн бодит дэмжлэг байх; аливаа болзол шалгуургүй, барьцаагүй, сайн дурын үндсэн дээр хийгдсэн байх; нийлүүлж буй тохижилт, тоног төхөөрөмж нь стандартад нийцсэн, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн байх;

		нэвтрүүлэх, өргөтгөх, шинэчлэх		тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байх;	
2	Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 20.1, 20.2; Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 211.1;	өргөн нэвтрүүлгийн хөгжлийг дэмжих, радио, телевизийн үндэсний бүтээл үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Засгийн газрын 2023 оны 364 дүгээр тогтоолоор баталсан “Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулах журам”	Харилцаа холбооны үйлчилгээг хүргэх талаарх төрийн болон салбарын бодлогод нийцсэн байх; Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сангийн дэмжлэгт хамрагдаагүй байх; Харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байх;	амьдралын чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн бодит дэмжлэг байх; аливаа болзол шалгуургүй, барьцаагүй, сайн дурын үндсэн дээр хийгдсэн байх; нийлүүлж буй тохижилт, тоног төхөөрөмж нь стандартад нийцсэн, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан, орчин үеийн дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлсэн байх;
Хоёр.Төрийн үйлчилгээг хүртээмжтэй, нэгдсэн байдлаар хүргэх бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлэх, мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт					
3	Өргөн нэвтрүүлгийн тухай хууль;	телевизийн нэвтрүүлгийг дохионы хэлний хэлмэрчтэй,	Харилцаа холбооны зохицуулах хорооны ... оны ... р тогтоолоор	Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн 9.2, 9.4, 9.5,	

	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль;	хадмал тайлбартай нэвтрүүлэх	батлагдсаннөхцөл, шаардлага Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 23.5.4.хадмал тайлбар, дохионы хэл бүхий нэвтрүүлэг;	9.6, 9.7, 9.14-т заасан харилцаа холбоо, мэдээлэл технологийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй байх;	
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 5.1.3, 6.2, 8.1, 8.48 11.2, 22.1.5;	Цахим хуудасны хүртээмжийг нэмэгдүүлэх	Веб контентын хүртээмжийг нэмэгдүүлэх аргачлал (ISO/IEC 40500:2012 WCAG- Web Content Accessibility Guidelines)		
5	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2, 25.11;	бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, цахим орчинд хүүхдийг хамгаалах чиглэлээр мэдлэг олгох сургалт зохион байгуулах, зөвлөх үйлчилгээ үзүүлэх;	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 141 дүгээр тогтоолоор батлагдсан “Бүх нийтийн цахим ур чадварын бүтцийн хүрээ батлах тухай”, Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Хууль зүй, дотоод хэргийн		Хүүхэд хамгааллын тухай тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4-т заасны дагуу Хүүхэд хамгааллын бодлогыг баталж, хэрэгжүүлсэн байх;

			сайд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд нарын хамтарсан 2025 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн А/53, А/95, А/76 дугаар тушаалаар батлуулсан “Цахим орчинд хүүхдийг хориотой болон хүүхдэд хортой агуулгаас урьдчилан сэргийлэх, хамгаалах журам”-ын 2.4.1-д “цахим орчинд хүүхэд хамгааллын талаар өөрийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдах, мэргэшсэн этгээдээс зөвлөгөө, туслалцаа авах”		
6	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл;	бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх, цахим орчинд хүүхдийг хамгаалах			телевиз, радиогоор нэвтрүүлсэн контентын цаг, нэвтрүүлэлтийн давтамж (7 хоног, сар, улирлаар)

		чиглэлээр хэвлэмэл болон цахим гарын авлага боловсруулах, контент бүтээх, олон нийтэд түгээх;			олон нийтийн мэдээллийн хэрэгсэл (social media)-ээр түгээсэн контентыг үзсэн хэрэглэгчийн тоо, бусдад хуваалцсан (share) тоо; болон хэвлэж, олон нийтэд түгээсэн баримт, мэдээлэл (санхүүгийн болон бусад) Түгээсэн контент үзэлтийн тоо Бүтээсэн контент
7	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл;	мэдээлэл, харилцаа холбооны технологи ашиглан хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх;			
8	Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйл;	хүүхдийн цахим аюулгүй байдлыг хангахад чиглэсэн программ хангамж, платформ бүтээх, хөгжүүлэх			
Гурав.Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих Виртуал бүсэд бүртгэгдсэн					

хуулийн этгээдэд оруулсан хөрөнгө оруулалт					
9	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль;	Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр бий болгох, инновацын экосистем чадавхыг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх үйлдвэрлэлийг дэмжих	“Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн үйл ажиллагааны журам” болон “Виртуал бүсэд бүртгэлтэй хуулийн этгээдэд татварын болон татварын бус дэмжлэг үзүүлэх журам”	Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн 4.1.4-т заасан үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байх	Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр бий болгоход ашиглах боломжтой, техникийн хувьд ашиглалтын шаардлага хангасан өндөр хүчин чадалтай технологийн дэд бүтэц /GPU, дата төвийн тоног төхөөрөмж, компьютер/ зэрэг үндсэн хөрөнгийг элэгдэл тооцох үндсэн хөрөнгийн ангилалд хамруулна.